



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар A/63

Жаргалтхаан

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын үндэсний их баяр наадмын нэгэн төрөл, ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн шагайн харвааг нийтэд таниулах, түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, сумын аварга баг, харваачдыг шалгаруулах зорилгоор зохион байгуулж буй сумын аварга шалгаруулах “Үндэсний шагайн харваа” тэмцээний зардалд зориулж 330,000 (гурван зуун гучин мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 330,000 (гурван зуун гучин мянган) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч З.Жанчив нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Ганбат)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232401149